



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠨ  
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
 ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/136

Алтай хот

**Хяналт шалгалт хийх ажлын  
 хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5<sup>3</sup>.1, 5<sup>3</sup>.2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд болон аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний 3 дугаар хавсралтын 1, 2, 3, 4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж байгаа төсөл арга хэмжээнүүдээс барилга, инженерийн шугам сүлжээ, өргөх байгууламж, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, түүнд ашиглаж буй бетон зуурмагийн чанар, техникийн аюулгүй байдалд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- |                 |  |
|-----------------|--|
| Комиссын дарга: | Д.Алтанзагас (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, улсын ахлах байцаагч)   |
| Гишүүдэд:       | Г.Мөнхөө (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн авто замын хяналтын улсын байцаагч)        |
|                 | Д.Отгонжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч) |
|                 | О.Мөнхбаатар (Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)   |
|                 | Ц.Түмэнжаргал (Боловсрол, шинжлэх ухааны газрын боловсролын хяналтын улсын байцаагч)   |

2.

- А.Оюун-Эрдэнэ (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч)
- М.Мөнхцэцэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн)
- З.Отгонцэцэг (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
- Б.Цэрэндаваа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын гэрээт хяналтын инженер)
- Н.Гэрэлтуяа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)
- Ц.Бадамгэрэл (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)
- Нарийн бичгийн дарга:Б.Батбилэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)

2.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг удирдамж батлуулан салбарын хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар хөдлөлтийн болон болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3.Хяналт, үзлэг шалгалт хийсэн тайланг 2023 оны 06 дугаар сарын 09, 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн дотор тус тус аймгийн Засаг даргын Удирдлагын Зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажиллахыг ажлын хэсэг (Д.Алтанзагас)-т даалгасугай.

ОРЛОГЧ



Т.ЧИНБАТ